



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 18 өдөр

Дугаар А/579

Есөнбулаг

Төсвийн сар улирлын 2023 оны  
хуваарь батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.7 дахь заалт, Сангийн сайдын 2022 оны 279 дүгээр тушаал, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 23 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн орлогын сарын хуваарийг нэгдүгээр, орон нутгийн төсвөөс сумдад олгох санхүүгийн дэмжлэгийг хоёрдугаар, байгууллагуудад олгох санхүүжилтийг гуравдугаар, Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгийг дөрөвдүгээр, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний санхүүжилтийг тавдугаар, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг зургаадугаар, орон нутгийн авто замын сангийн санхүүжилтийг долоодугаар, Есөнбулаг сумын төсвөөс аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг наймдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Төсвийн орлогыг баталсан хуваарийн дагуу бүрдүүлж ажиллахыг Татварын хэлтэс (Н.Энхтуяа), сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.
3. Аймгийн ерөнхий орлогод 563,397,100 төгрөгийг хуваарийн дагуу төвлөрүүлэхийг Есөнбулаг сумын Засаг дарга (А.Алтанхуяг)-д даалгасугай.
4. Сумдын болон төсвийн байгууллагуудын зардлыг батлагдсан хуваарийн дагуу санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг), сумын Засаг дарга нарт тус тус зөвшөөрсүгэй.
5. Төсвийн гүйцэтгэлийн сар улирлын мэдээ, тайланг хуулийн хугацаанд гаргаж тайлагнах, төсвийн орлого зарлагын сар бүрийн гүйцэтгэлд хяналт тавин, ил тод нээлттэй байдлыг хангаж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг), Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба (Ж.Төгөлдөр), захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР